

БОГ МАЛЫН ХЭЭЛТҮҮЛЭГЧ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 04 дугаар сарын 26

Рашаант

Нийт төсөв: Улсын төсвийн хөрөнгө оруулалт 28,0 сая төгрөг

Гүйцэтгэх ажил:

Багц 1: Төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор стандартын шаардлага хангасан Залаажинст-Эдрэн үүлдрийн 40 ухна ишиг, Баянбулаг омгийн 40 хурган хуц нийлүүлэх-28,0 сая,

БАГЦ 1: Өсвөр хээлтүүлэгч нийлүүлэх ажлын техникийн тодорхойлолт

Малын генетик нөөцийн тухай хуулийн 11.1, 11.6.2, 11.6.4, 18.2.3-р зүйл, ХХААХҮС-ын 2024 оны А/137 тушаалыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд Шинэжинст, Баян-Өндөр сумаас Залаажинст-Эдрэн үүлдрийн өсвөр ухна 40 толгой, Баянбулаг сумаас Баянбулаг омгийн өсвөр хуц 40 толгой худалдан авч төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх ажлыг тусгаж хэрэгжүүлэхээр санал хүргүүлж байна.

Үндэслэл:

Үзлэг ангилалтад хамрагдах шаардлагатай үржлийн 1,6 сая хээлтэгч, 25873 хээлтүүлэгч байдаг хэдий ч технологийн зохистой хугацаанд үзлэг ангилалтад хамруулж чадахгүй, ашиг шимт чанараа үнэлүүлж, баталгаажуулах, үржлийн малын удам гарваль, ашиг шимийн бүртгэл хөтлөгдөхгүй байгаа бөгөөд стандартын шаардлагад тэнцэхгүй хээлтэгч, хээлтүүлэгч үржилд ашигласаар байгаа нь малын чанарыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэхэд муугаар нөлөөлж байна.

Үржлийн мал үзлэг ангилалтад хамрагдахгүй байгаагаас гарал үүсэл нь тодорхой биш, ялган тэмдэглэгээ хийж бүртгэлд ороогүй, ашиг шимийн гарц, чанар тодорхойгүй, цаашид мал сүргийн чанарыг сайжруулах үржил селекцийн хөтөлбөр боловсруулахад тоон үзүүлэлт судалгаа дутагдалтай байна. Бог малын хээлтэгч, хээлтүүлэгчийн тохирооны зохист хэмжээ алдагдан 1 хуцанд 69 хээлтэгч, 1 ухнанд 85 хээлтэгч оногдож байгаа зэрэг нь малын чанар болон сүргийн нөхөн үйлдвэрлэлд муугаар нөлөөлөхөөр байна. Иймд нутгийн малын ашиг шимийн түвшинг тогтоох, цөм сүргийн мал бүрдүүлэх болон дутагдалтай байгаа богийн үржлийн өсвөр хээлтүүлэгч өсгөн бойжуулах шаардлагатай байна.

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх хууль эрх зүйн заалт	<p>Малын генетик нөөцийн тухай хууль:</p> <p>11.1.Малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, малд, үзлэг ангилалт хийх, удам гарваль, ашиг шимийн гарц, чанарыг тодорхойлох, үр төлийн шинж чанар үнэлэх, удам зүйн үнэлгээ хийх, үржил селекцийн ажлын үр дүнг хянан баталгаажуулах, үржүүлгийн хөтөлбөр боловсруулах, сайжруулагч малыг үржилд тохируулан сонгох, цөм сүрэг бүрдүүлэх, малд зохиомол хээлтүүлэг хийх, гойд ашиг шимт мал шалгаруулах, үржлийн малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, малын арчилгаа маллагаа, тэжээллэгийн технологийн чиглэлээр малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн зааварчилгаа, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд хамруулна.</p> <p>11.6.2.үүлдэр, омгоос цөм сүрэг бүрдүүлэх, өсвөр малыг үржилд шилж сонгох, ялган суурилах, үржлийн нас хүртэл бойжуулах, борлуулах,</p> <p>11.6.4.бог малын, шаардлагатай тохиолдолд бод малын хээлтүүлэгчийг сүргээс тусгаарлан маллах, хяналтад авч бүртгэх, түрээсийн гэрээгээр ашиглуулах,</p> <p>18.2.3.төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх, үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, гойд ашиг шимт сайжруулагч малыг шалгаруулах, улсын бүртгэл, үржлийн дэвтэр хөтлөх,</p>
2	Хамрах хүрээ, хугацаа	Төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч сонгон шалгаруулах ажлыг үржлийн ажлын технологийн хугацаанд хэрэгжүүлнэ.
3	Гүйцэтгэх ажил	<p>Залаажинст Эдрэн үүлдрийн 40 ухна ишиг, Баянбулаг омгийн 40 хурган хуц шилэн сонгох ажлыг хэрэгжүүлнэ.</p> <p>Гүйцэтгэх ажилд дараах зардлууд багтана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Өсвөр хээлтүүлэгч худалдан авах үнэ 2.Өсвөр хээлтүүлэгчийг дараа оны 9 сар хүртэл маллах малчны хариулгын хөлс

		<p>3.Бар код бүхий эзэмгний үнэ</p> <p>4.Өсвөр хээлтүүлэгч шилэн сонгох үеийн томилолт, шатахуун болон бусад зардал</p> <p>5.Өвөл, хаврын улирлын нэмэгдэл тэжээлийн үнэ</p>
4	Аж ахуй нэгжид тавих шаардлага, бүрдүүлэх материал	<p>1. Ангилагч, мал зүйчийн чадварын мэдээлэл, батлах бичиг баримт</p> <p>2. Аж ахуйн нэгжийн мэдээлэл /санхүүгийн тайлан, бусад/</p> <p>3. Үржлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий гэрчилгээ</p> <p>4. Ижил төстэй ажил заахгүй</p>
5	Төлбөр санхүүжилт	<p>Захиалагч 70% урьдчилгаа төлбөрийг гэрээ байгуулсан гүйцэтгэгчид төлнө.</p> <p>Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг зөвхөн гэрээт ажлыг гүйцэтгэхэд гарах зардалд зарцуулна. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг энэ зорилгод ашигласныг нотлохын тулд мал сүрэгт ангилалт, шилэн сонголт хийсэн бүртгэлийг захиалагч талд ирүүлнэ.</p> <p>Төлбөрийн үлдэгдэл 30%-н санхүүжилтийг акт, бусад бичиг баримтыг үндэслэн олгоно.</p>
6	Үр дүн	<p>Төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор стандартын шаардлага хангасан Залаажинст Эдрэн үүлдрийн 40 ухна ишиг, Баянбулаг омгийн 40 хурган хуц шилэн сонгож, хүлээлгэн өгсөн байна.</p>
7	Боловсруулалтын явц болон хяналт	<p>Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн алба, үржлийн улсын байцаагч, сумын Хөдөө аж ахуйн тасгийн Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, малын генетик нөөцийн бүртгэл, үржил, селекцийн асуудал хариуцсан мал зүйч ажлын явцад байнгын хяналт тавьж ажиллана.</p>

ТОДОРХОЙЛОЛТ БАТАЛСАН:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ **Б.МӨНХТОГТОХ**

